



ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Төсвийн зөвлөлөөс эрхлэн гаргав.

2023 оны 5 дугаар сар
Цуврал №5

МОНГОЛ УЛСЫН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТ

АСУУДАЛ | НӨХЦӨЛ БАЙДАЛ | ШААРДЛАГАТАЙ АЛХМУУД



НИЙТИЙН ТӨСӨВ, САН ХӨМРӨГИЙГ УДИРДАХАД
ТАТВАР ТӨЛӨГЧ ИРГЭН БҮР МЭДЭЭЛЭЛТЭЙ
ОРОЛЦОЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЭРХТЭЙ.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ

Төрийн төсөв, санхүүд тавих хяналтыг сайжруулах, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлого шийдвэрт иргэдийн дуу хоолойг тусгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төсвийн Зөвлөл”-ийг Нээлттэй Нийгэм Форумгаас санаачлан 2021 оны 3 дугаар сард байгуулсан юм. Төсвийн Зөвлөл нь хараат бус шинжээчдээс бүрдэж буй бөгөөд иргэд нийтийн төсөв, сан хөмрөгийг удирдахад мэдээлэлтэй оролцох, хяналт тавих боломж нөхцөлийг бүрдүүлэх үндсэн дээр нийтийн сан хөмрөгийн оновчтой зарцуулалтыг дэмжих зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Н.Энхбаяр, Эдийн засагч

Н.Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Монгол Улс дахь менежер

А.Батпүрэв, “Санхүүгийн хүртээмж-хөгжил” ТББ-ын Үүсгэн байгуулагч, гишүүн

С.Боргил, Санхүүч, “Сэргэлт Консалтинг Групп” компанийн захирал

Доктор Ч.Нарантуяа, МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ц.Мөнхбаяр, Эдийн засагч, санхүүч, Байэр Адвайзори ХХК-ийн зөвлөл

П.Эрдэнэжаргал, Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

Доктор Д.Оюунбадам, Төсвийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Төсвийн Зөвлөл (цаашид Төсвийн зөвлөл гэх) нь улсын санхүү, төсвийн асуудлаар тогтмол хуралдаж, хэлэлцүүлгийн дүнг бодлогын шинжилгээ болгон эрхлэн гаргаж байна.

Төсвийн зөвлөл нь ээлжит хэлэлцүүлгээ “2021 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн зөрчлүүд” сэдвээр 2022 оны 11 дүгээр сард хийсэн. Энэ удаагийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлуудыг Зөвлөлийн гишүүн Ч.Нарантуяа нэгтгэв.

АСУУДАЛ

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд жил бүр аудит хийгдэж тайлан, зөвлөмж гардаг боловч зөвлөмжийн хэрэгжилт сул байна. Тиймээс төсвийн гүйцэтгэлийн бодит хяналт сул, аудитын дүгнэлт, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нэр төдий, аудитын ач холбогдол бага байна.

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Төрийн аудит нь (1) төсөвлөлт нь бодитой эсэхийг тодорхойлох, (2) хууль хэрэгжиж буй эсэх, (3) зарцуулалтад хяналт тавьж, шаардлагатай бол хариуцлага тооцох зорилготой байдаг.

Төрийн аудитын эрх зүйн орчин хангалттай, олон улсын аудитын стандартад нийцсэн байна.

Төрийн аудитын эрх зүйн орчин 2020 онд шинэчлэн найруулсан Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдож байна.

- Төрийн аудитын хамарч буй хүрээ нь иж бүрэн байна. Төрийн аудит нь санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудит хэмээн гурван төрөлтэй байна. УИХ-аас бусад байгууллагад бүх төрлийн аудит хийгдэх бөгөөд УИХ-ын хувьд зөвхөн санхүүгийн аудит хийхээр хуулинд заасан. Төрийн аудитад хамрагдсадын хувьд төсвийн байгууллага, тусгай сан, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн

болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төрийн чиг үүргийг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд зэрэг нийтийн өмчийг бүрэн болон хэсэгчлэн захиран зарцуулах эрхтэй бүх нэгжүүд хамрагдаж байна.

- Аудитын стандарт нь олон улсын стандартад нийцсэн, тодруулбал олон улсын стандартыг албан ёсоор монгол хэл рүү орчуулсан, мөн үндэсний стандартыг боловсруулсан.
- Аудитын дүгнэлтийн тайлан нь дүгнэлт болон зөвлөмжөөс бүрддэг, зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг Үндэсний аудитын газар (ҮАГ)-т заасан хугацаанд мэдэгдэх үүрэгтэй, хууль тогтоомж зөрчсөн бол албан шаардлага өгнө, төлбөрийн акт тогтоохоор заасан.
- Дүгнэлт нь зөрчилгүй, хязгаарлалттай, сөрөг, дүгнэлт гаргахаас татгалзсан гэсэн 4 төрөл байна.

Аудитын тайланг УИХ-аар хангалтгүй хэмжээнд хэлэлцдэг бөгөөд Засгийн газрын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн төсөлд ямар нэг өөрчлөлт оруулаагүй, зөвлөмж гаргаагүй байна.

Эрх зүйн энэ орчны хүрээнд 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар 2022 оны 6-р сарын 8-ны өдөр гүйцэтгэж, Засгийн газар, УИХ-д хүргүүлсэн байна.

Аудитын тайланг УИХ-аар хэлэлцсэн байдлыг авч үзвэл:

- Засгийн газар 2021 оны улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг 2022 оны 6 сарын 20-ны өдөр УИХ-д өргөн барьсан, УИХ-ын бүх байнгын хороод тайланг

2022.7.1-7.5-ны өдрүүдэд тус бүр нэг удаа хуралдаж хэлэлцсэн.

- Байнгын хорооны дундаж ирц 57.3 хувь, хэлэлцсэн дундаж хугацаа 45 минут байна. Энэ асуудлыг хамгийн хурдан хэлэлцсэн нь 16 минутад багтаасан бол, хамгийн удаан хэлэлцсэн нь Нийгмийн бодлогын байнгын хороо бөгөөд нийт 1 цаг 46 минут зарцуулжээ.
- УИХ-ын нэгдсэн чуулганаар 2022 оны 7 сарын 6-ны өдөр өдөр хэлэлцсэн 10 асуудлын 2 дахь асуудал нь гүйцэтгэлийн аудитын тайлан байсан. Нийт 52 гишүүн оролцож, 34 минут хэлэлцжээ. 27 гишүүн батлахыг дэмжсэн, 21 гишүүн татгалзсан буюу 52.9 хувь дэмжлэгтэйгээр гүйцэтгэл батлагдсан.
- УИХ-ын тогтоол Засгийн газрын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн төсөлд ямар нэг өөрчлөлт оруулаагүй, зөвлөмж гаргаагүй. УИХ зөвлөмж гаргах эрх зүйн шаардлага байхгүй.

2021 оны төсвийн гүйцэтгэл нь бодлого болон хууль, эрх зүйн зохицуулалттай зөрчилдсөн байна.

ҮАГ-ын аудитын дүгнэлтээс зарим чухал гэж үзсэн зүйлсийг тодруулбал:

- Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагууд болох хуулийн 6.1.1-6.1.4 заалтууд биелсэн гэж аудитаар дүгнэсэн.
- Төсвийн төлөвлөлтийн үе шатанд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль зөрчиж Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулсан.
- Төсөвт тодотгол хийхдээ орлогыг 2.2 хувиар, зарлагыг 12.9 хувиар нэмэгдүүлсэн нь орлого, зарлагын зохистой харьцааг

алдагдуулсан гэж Үндэсний аудитын газар (ҮАГ) үзсэн.

- 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолыг зөрчсөн. Үүнд нийт 11.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна.
- “Эрүүл мэндийг хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц арга хэмжээ”-нд 10 их наяд төгрөг зарцуулсан боловч хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн 56 төсөл дээр ямар нэг үнэлгээ хийгдээгүй байна.
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээг нэгдсэн бодлогоор төлөвлөх талаар хууль болон журам нь байгаа хэдий ч хэрэгжихгүй байна гэж Үндэсний аудитын газар (ҮАГ) дүгнэсэн.
- Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт орсон боловч 2021 оны төсөвт огт ороогүй 79.2 тэрбум өртөг бүхий 6 төсөл байна, үүний зэрэгцээ өртөгийг нь бууруулж оруулсан 74.4 тэрбум өртөг бүхий 4 төсөл хөтөлбөр байна. Гэтэл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ороогүй, төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд тусаагүй 111 ажил орсон нь нэгдсэн төсөв нь улсын хөрөнгө оруулалтын бодлоготой уялдаагүй байгааг нотолно.
- Зарим урсгал зардлын шинжтэй төсвийг хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж байгааг илрүүлсэн байна.
- www.publicinvestment.gov.mn – нэгдсэн сайтыг 2019 онд нээсэн нь нааштай өөрчлөлт болсон байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт сул байна.


Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитын хүрээнд Үндэсний аудитын газар (ҮАГ)-аас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, дүнг аудитын тайланд нэгтгэдэг. ҮАГ-аас нийт 5605 байгууллагын түүвэрлэн шалгалт хийхэд нийт байгууллагын 41.2 хувьд нь ямар нэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Хуулийн дагуу сарын, хагас жилийн болон жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа мэдээлээгүй 1,531 төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар байна.
- Байгууллагууд нийт 472.1 тэрбум төгрөгийн 13,173 удаагийн орлого, зарлагыг мэдээлээгүй байна.
- Хугацаа хоцроосон 1,122 байгууллага байна.
- Бусад зөрчлийн хувьд худалдан авалтын зөрчилтэй байгууллага 6.2 хувь, өр авлага үүсгэсэн шийдвэрийн зөрчилтэй байгууллага нийт байгууллагын 10.6 хувь байна.

ҮАГ-аас 158 алдааг залруулах, 1189 зөвлөмж, 864 зөрчил арилгуулах албан шаардлага, 101 байгууллагад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд төсвийн нийт дүнгээрээ орлогыг дутуу төвлөрүүлсэн болон зарлагыг хэтрүүлсэн байдал илрээгүй байна.

ЗУРАГ 1. ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХУВИАР



Эх сурвалж: Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жилээр (1212.mn)

Сүүлийн 5 жилийн байдлаар 2020 оноос бусад жилүүдэд Монгол улсын нэгдсэн төсвийн нийт орлогын гүйцэтгэл төсөвлөсөн дүнгээс давж биелсэн, харин зарлага төсөвлөсөн дүгээр бага байна. 2021 онд орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 3.9 хувиар давсан, зарлага 3.5 хувиар хэмнэгдсэн ерөнхий тоо гарсан байна.

Хэдийгээр нийт дүнгээрээ орлого бүрэн

төвлөрсөн боловч татвар, орлогын зарим нэг төрөл дээр гүйцэтгэл төлөвлөгөөндөө хүрээгүй байна.

Ерөнхий дүнгээрээ татварын болон бусад орлогын гүйцэтгэл төлөвлөгөөнөөс давсан боловч Ирээдүйн өв санд хуримтлагдсан хөрөнгө, онцгой албан татвар, бусад татвар ба хураамж, нийтлэг татварын бус орлогын дүн төсөвлөсөн дүндээ хүрээгүй байна.

ХҮСНЭГТ 1. ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

	2020 он		2021 он	
	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	10,883.0	10,444.2	13,908.1	14,306.4
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	55.2	66.2	612.8	627.9
ИРЭЭДҮЙН ӨВ САН	943.2	914.1	1,062.4	967.0
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	9,884.6	9,463.8	12,232.9	12,711.4
1. Татварын орлого	8,905.9	8,511.6	10,707.8	11,299.9
1.1. Орлогын албан татвар	2,564.3	2,227.3	3,061.4	3,326.1
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	872.1	864.4	1,099.8	1,147.3
1.1.2. ААНБ-ын орлогын албан татвар	1,736.4	1,398.5	2,010.9	2,211.6
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,522.4	1,586.0	1,882.1	2,286.0

1.3. Хөрөнгийн албан татвар	175.3	154.9	183.0	201.1
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	2,278.0	2,209.0	2,804.0	2,837.7
1.5. Онцгой албан татвар	734.9	776.9	879.2	827.0
1.6. Тусгай зориулалтын орлого	16.0	17.1	15.0	16.6
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	771.0	740.7	935.0	938.9
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	844.0	799.7	948.1	866.5
2. Татварын бус орлого	978.7	952.2	1,525.0	1,411.5
2.1. Нийтлэг татварын бус орлого	822.7	785.0	1,368.0	1,249.7
2.2. Хөрөнгийн орлого	1.5	1.2	1.4	2.0
2.3. Тусламжийн орлого	154.5	166.0	155.6	159.8
2.4. Төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0

Эх сурвалж: Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жилээр (1212.mn)

Зарлагын хувьд 2021 онд эргэж төлөгдөх дотоод цэвэр зээлээр 862.2 тэрбум төгрөг авахаас 404.8 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

ХҮСНЭГТ 2. ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

	2020 он		2021 он	
	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	15,137.3	13,904.3	16,204.1	15,630.4
А.УРСГАЛ ЗАРЛАГА	11,568.9	10,828.9	13,460.8	12,804.0
1. Бараа, үйлчилгээний зардал	5,257.9	4,851.2	4,955.9	4,702.0
1.1. Цалин, хөлс	2,716.5	2,648.9	2,593.0	2,531.7
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	2,541.4	2,202.3	2,362.8	2,170.3
2. Хүү	979.0	939.2	971.5	835.7
3. Татаас ба урсгал шилжүүлэг	5,332.0	5,038.5	7,533.4	7,266.3
3.1. Татаас	458.2	375.1	501.0	453.7
3.2. Урсгал шилжүүлэг	4,873.8	4,663.5	7,032.4	6,812.6
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,514.1	3,034.2	3,304.7	2,982.2
1. Барилга байгууламж	2,368.0	2,072.0	2,078.2	1,941.1
2. Их засвар	172.2	145.0	147.2	128.5
3. Тоног төхөөрөмж	0.0	0.0	0.0	0.0
4. Хөрөнгийн бусад зардал	973.8	817.3	1,079.2	912.7
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	54.3	41.1	-561.3	-155.8
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	-170.2	-119.5	-712.3	-311.7
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	224.5	160.6	151.0	155.9

Эх сурвалж: Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жилээр (1212.mn)

Дотоод цэвэр зээлээр 457.4 тэрбум төгрөгийг дутуу авсны дотор ААН, байгууллага болон улс, орон нутгийн төсөвт байгууллага, төсөлд олгосон 173.9 тэрбум, Эрүүл мэндийн даатгалын сангийн 129.2 тэрбум, Нийгмийн даатгалын сангийн 74 тэрбум төгрөгийн авлага дутуу төвлөрсөн байна.

Зарим төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитын дүгнэлтэд томоохон хэмжээний

алдаа, зөрчил илэрсэн байна.

Доорх хүснэгтэд дурдсан төсвийн ерөнхийлөн захирагч (ТЕЗ) нарын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд дээр нийт 3.3 их наяд төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Үүний дагуу ҮАГ-аас алдааг залруулах, төлбөрийн акт тавих, албан шаардлага хүргүүлэх, зөвлөмж өгөх, хуулийн хариуцлага арга хэмжээг авсан байна.

ХҮСНЭГТ 3. ЗАРИМ ТЕЗ-ИЙН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ БАЙГУУЛЛАГУУДЫН АУДИТЫН ДҮГНЭЛТ (ТЭРБУМ ТӨГРӨГ)

Төсвийн ерөнхийлөн захирагч	Нийт алдаа, зөрчил	Залруулсан алдаа	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хуулийн хариуцлага тооцох
Уул уурхай, хүнд үйлдвэр	1,300.00	106.30	4.80	304.80	976.50	
Эрүүл мэнд	561.20	141.90	0.30	225.00	194.00	5 албан шаардлага, 3 асуудал
Хүнс, ХАА, хөнгөн үйлдвэр	463.30	43.70	2.50	412.70	4.40	
Зам, тээврийн хөгжил	333.40	324.60	0.70	3.50	2.40	2.2 тэрбумын 6 санал
Эрүүл мэндийн даатгалын сан	315.00	0.50	9.60	305.30	1.00	
Эрчим хүч	152.30	119.20	0.40	6.60	25.00	1 тэрбумын 6 санал
Нийгмийн даатгалын сан	133.10	3.20	0.10	117.40	12.40	
Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	61.10	37.10	0.30	19.90	3.80	3 санал, 2 асуудал
Барилга, хот байгуулалт	2.20	0.20	0.20	1.40	0.40	
НИЙТ	3,321.60	776.70	18.90	1,396.60	1,219.90	

Эх сурвалж: Монгол Улсын 2021 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан болон аудитын тайланг УИХ-ын байнгын хороодоор хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл

Аудитын явцад зарим төсвийн ерөнхий захирагчдын хувьд томоохон дүнтэй зөрчлүүд илэрсэн байна. Эдгээрийг нийт алдаа, зөрчлийн дүнгээр нь Хүснэгт 3-т тоймлон харуулав. Зөрчлийг боломжтой

бол санхүүгийн тайланд өөрчлөлт оруулан залруулах; аудитын газраас зөвлөмж өгөх; хууль тогтоомж зөрчсөн болон албан үүргээ биелүүлээгүй бол албан тушаалтанд албан шаардлага өгөх; хөрөнгийн зарцуулалттай

холбоотой зөрчил гарсан бол төлбөрийн акт тогтоох; улмаар эрүүгийн болон бусад хариуцлага хүлээлгэх шаардлагатай бол шүүхээр энэ асуудлыг шийдвэрлэх гэсэн үе шаттай арга хэмжээ авдаг.

Хүснэгт 3-аас харахад, нийт алдаа зөрчлийн 23.4 хувийг нь газар дээр нь залруулсан, 42 хувьд нь албан шаардлага хүргүүлсэн, 0.6 хувьд нь төлбөрийн акт тогтоосон, 36.7 хувьд нь зөвлөмж өгсөн байна. Төсвийн ерөнхий захирагч нарын дунд хөрөнгийг буруу зарцуулсан, шамшигдуулсан тохиолдол харьцангуй ховор байгаа хэдий ч хууль журам зөрчиж, үүргээ биелүүлэхгүй байх явдал түгээмэл байна.

Аудитын зөвлөмжийн хэрэгжилт сул байна.

2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитаар Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 2, нийт 8 зөвлөмж хүргүүлсэн. Сангийн яамнаас зөвлөмжийн биелэлтийг 93 хувийн хэрэгжилттэй гэсэн албан бичиг ирүүлсэн бол ҮАГ биелэлтийг 50.3 хувьтай гэж үнэлсэн байна.

2020 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлтэй холбоотой нийт 8 зөвлөмж хүргүүлсний хариуг 2021 оны 12 сарын 1-ний дотор ирүүлэх шаардлагатай хэдий ч 2022 оны 5 сарын 26-ны өдөр Сангийн яамнаас 88.7 хувийн биелэлттэй гэж ирүүлснийг ҮАГ нягтлаад 61.7 хувь байсан гэж дүгнэсэн байна.

Дотоод аудитын тогтолцоо төлөвшөөгүй байна.

Төсвийн тухайн хуульд төсвийн байгууллага дотоод аудитын нэгжтэй байна гэж заасан. Дотоод аудитын дүрмийг Засгийн газраас 2015 онд баталсан. ҮАГ-аас 2021 оны 12 сарын 28-ны өдөр төрийн байгууллагуудын дотоодын аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилтэд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гаргасан. Төрийн байгууллагуудын

дотоод аудитын тогтолцоо төлөвшөөгүй, стандартын шаардлага хангахгүй, хүний нөөц тогтворгүй, зохион байгуулалт болон төсвийн хараат бус байдал хангагдаагүй гэж дүгнэсэн байна. Харин Монголбанк дүрэм болон стандартын дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллаж байгаа ҮАГ-аас онцолжээ.

Дүгнэж хэлэхэд, төрийн аудитын эрх зүйн орчин сүүлийн жилүүдэд сайжирч, олон улсын стандартад нийцэх болсон. ҮАГ-аас төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, хуулийн хугацаанд Засгийн газар болон УИХ-д хүргүүлсэн байна. Гэсэн хэдий ч аудитын агуулга санхүүгийн гүйцэтгэлд илүү төвлөрч, зарим тохиолдолд хэтэрхий ерөнхий шинж чанартай байна. УИХ аудитын тайланг маш богино хугацаанд, бага цаг зарцуулан хэлэлцдэг. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн төсөлд ямар нэг өөрчлөлт оруулахгүй, дүгнэлт, зөвлөмж гаргахгүйгээр баталж байна. Ялангуяа төсвийн ерөнхийлөн захирагч нартай холбоотой том дүнтэй алдаа, зөрчлүүдийг байнгын хороод дутуу дулимаг хэлэлцэж, төсвийн гүйцэтгэлийн хяналтын үүргээ сул гүйцэтгэж байна. Улсын нэгдсэн төсөв хөрөнгө оруулалтын улсын төлөвлөгөөтэй зөрчилдөж, уг төлөвлөгөөнд байсан олон төсөл, хөтөлбөр төсөвт тусгагдаагүй хэрнээ, төлөвлөгөөнд огт байхгүй 100 гаруй ажил орж ирсэн нь төрийн бодлогын уялдаа сул байгааг илэрхийлж байна. Мөн хэмнэлтийн тухай тогтоол зөрчиж, 10 их наядын эрүүл мэндийн 56 төслийн үнэлгээ хийгээгүй байгаа нь төсвийн хяналт сул байгааг илэрхийлнэ. Өмнөх жилүүдийн туршлагаас харахад, Засгийн газрын зүгээс аудитын зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т тогтоосон хугацаанаас олон сарын дараа хүргүүлж байгаагаас гадна зөвлөмжийн дагуу авсан хэмжээ нь огт хангалтгүй, биелэлт маш сул байна.

ШААРДЛАГАТАЙ АЛХМУУД

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, түүний үр нөлөөг сайжруулахын тулд дараах алхмуудыг авч хэрэгжүүлэх тал дээр УИХ, Засгийн газар, Сангийн яам болон төрийн холбогдох бусад байгууллага анхааран ажиллахыг Төсвийн Зөвлөлөөс зөвлөж байна. Үүнд:

- Аудитаас гарсан зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах үүднээс Засгийн газраас зөвлөмжийг биелүүлэх, биелэлтийн талаар албан ёсны хариуг заасан хугацаанд ҮАГ болон УИХ-д хүргүүлдэг байх, хүргүүлээгүй тохиодолд хариуцлага тооцдог болох;
- Сангийн яам улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг ҮАГ-т хүргүүлээд аудит нь тайланг баталсан ч яг аль заалт зөрчсөн мэдээлэл байхгүй байна. Тиймээс мэдээллийн технологийг ашиглаж мэдээллээ цахимаар, дэлгэрэнгүй байдлаар нийтэд ил болгох;
- Төсөв батлагдахаас өмнө төсвийн задаргааг иргэд бүрэн харж байгаа. Гэтэл төсөв хэлэлцсэний дараа нэмж, хасагдах зүйл нь ороод УИХ-аар батлагддаг. ҮАГ-аас төсвийн хэлэлцүүлгийн явцад гарсан санал нь батлагдсан төсөвт буюу Сангийн яамнаас нэгтгэсэн төсөвт зөв туссан талаар дүгнэлт гаргаж байх;
- Дотоод аудит тухайн байгууллага дотроо байдаг. Яамны дотоод аудиторыг Төрийн нарийн бичгийн дарга томилж буй нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж байгаа. Яамны дотоод аудиторыг Засгийн газрын хэрэг эрхлэх газар (ЗГХЭГ)-аас буюу гаднаас томилдог болгох;
- ҮАГ-аас төсвийн гүйцэтгэлийг хянахдаа санхүүгийн үзүүлэлтээс гадна бодлого, гүйцэтгэлийн хүрэх үр дүн, зорилго, тэдгээрийн биелэлтийг анхаарч аудитын тайланд тусгах;
- УИХ-ын Зарлагын хяналтын дэд хорооны чадавх сул байгаа учир чадавхыг нэмэгдүүлэх;
- Засгийн газар, Сангийн яам аудитын зөвлөмжийн мөрөөр арга хэмжээ авч тайлангаа ҮАГ-т ирүүлэхдээ олон нийтэд ил болгох;
- Аудитын тайлан дээр өмнөх зөвлөмжийн хэрэгжилт гээд дүгнэлт хэсэг маш товч байгааг илүү дэлгэрэнгүй болгох;
- Аудитын өгч байгаа дүгнэлт болон хэрэгжилтэд олон нийтийг оролцуулж хэлэлцүүлэг хийх;
- Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг УИХ хэлэлцээд тогтоол, шийдвэр гаргадаг болох;
- Аудитын тайлангаас харахад худалдан авах ажиллагааг оройтож зохион байгуулдаг гэсэн дүгнэлт байна. Иймд төсвийн цаглабарт өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

Хавсралт 1. Монгол Улсын төсөв ба гүйцэтгэл, 2017-2023 он

	2017		2018		2019		2020		2021		2022		2023	
	Балгагдсан	Гүйцэтгэл	Балгагдсан	Гүйцэтгэл	Балгагдсан	Гүйцэтгэл	Балгагдсан	Гүйцэтгэл	Балгагдсан	Гүйцэтгэл	Балгагдсан	Гүйцэтгэл	Балгагдсан	Төсөөлөл
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,259,541.1	7,958,264.6	8,036,199.8	10,172,760.3	11,272,481.8	12,040,327.3	10,882,957.6	10,444,166.6	13,908,103.4	14,306,356.6	16,278,122.6	19,594,618.0		
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	242,417.9	325,680.2	122,747.2	206,986.6	322,000.0	94,596.6	55,151.2	66,242.9	612,800.0	627,922.2	751,713.6	132,718.6		
ИРЭЭДҮЙН ӨВ САН	333,345.1	357,722.8	508,744.3	620,693.6	1,068,520.0	1,040,219.9	943,205.0	914,085.5	1,062,430.0	966,999.6	0.0	540,000.0		
НИЙТ ТЭНЦЭЭРХҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	6,683,778.2	7,274,861.6	7,404,708.3	9,345,080.1	9,881,961.8	10,905,510.8	9,884,601.3	9,463,838.2	12,232,873.4	12,711,434.7	15,526,409.0	18,921,899.4		
1. Татварын орлого	5,717,767.4	6,315,131.9	6,356,870.3	8,227,776.1	8,694,525.2	9,813,195.8	8,905,869.0	8,511,605.1	10,707,841.5	11,299,930.3	13,634,377.7	17,065,395.2		
1.1. Орлогын албан татвар	1,354,833.5	1,613,192.8	1,449,067.2	2,091,089.9	2,114,101.6	2,555,734.1	2,564,343.4	2,227,324.1	3,061,437.6	3,326,079.1	2,950,115.9	3,509,682.1		
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	626,158.8	651,047.9	757,669.9	814,158.5	872,101.6	895,161.6	872,105.3	864,387.2	1,099,772.6	1,147,283.8	1,132,432.0	1,262,829.6		
1.1.2. Аж, ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	728,674.7	962,144.9	691,397.3	1,276,931.4	1,242,000.0	1,660,572.5	1,736,434.1	1,398,473.1	2,010,900.3	2,211,560.1	1,817,684.0	2,246,852.6		
1.1.3. Зарим бүтээгдэхүүний үнийн есэлтийн албан татвар	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,242,340.3	1,321,375.2	1,418,760.9	1,638,321.1	1,687,457.7	2,030,515.3	1,522,416.3	1,586,015.3	1,882,098.0	2,286,045.7	2,984,272.7	3,597,254.0		
1.3. Хөрөнгийн албан татвар	112,608.3	131,129.6	122,796.8	141,225.4	148,644.2	154,369.1	175,279.9	154,878.6	182,956.6	201,104.0	213,444.0	159,571.3		
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,448,504.9	1,618,492.1	1,517,318.4	2,195,907.2	2,321,100.0	2,486,268.1	2,277,958.5	2,208,953.7	2,804,000.0	2,837,709.7	3,496,800.0	4,530,000.0		
1.5. Онцгой албан татвар	511,577.7	519,721.5	684,315.0	754,440.2	837,800.0	863,406.5	734,906.1	776,886.3	879,200.0	826,982.9	1,002,200.0	966,000.0		
1.6. Тусгай зориулалтын орлого	11,941.1	12,386.6	12,057.2	13,063.7	12,200.0	16,355.0	15,957.9	17,071.7	15,000.0	16,597.7	17,200.0	20,000.0		
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	489,784.0	512,351.2	536,906.7	682,218.2	743,020.0	790,178.4	770,967.0	740,742.4	935,030.0	938,914.8	1,081,940.0	1,520,000.0		
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	546,177.6	586,482.8	615,648.0	711,510.3	830,201.6	916,369.2	844,039.9	799,733.0	948,119.4	866,496.4	1,888,405.1	2,762,887.8		
2. Татварын бус орлого	966,010.7	959,729.8	1,047,838.1	1,117,304.0	1,187,436.6	1,092,315.1	978,732.3	952,233.1	1,525,031.9	1,411,504.4	1,892,031.3	1,856,504.2		
2.1. Нийтлэг татварын бус орлого	888,236.7	896,708.4	936,611.0	1,027,675.0	1,035,624.5	1,003,117.3	822,742.0	784,979.7	1,367,981.1	1,249,709.0	1,593,341.4	1,285,819.2		
2.2. Хөрөнгийн орлого	1,197.1	1,187.9	1,227.1	1,123.6	1,328.6	823.3	1,540.1	1,219.1	1,423.5	2,028.5	170.5	185.0		
2.3. Тусламжийн орлого	76,576.9	61,833.5	110,000.0	88,505.4	150,483.5	88,374.4	154,450.3	166,034.3	155,627.2	159,767.0	298,519.4	570,500.0		
2.4. Төсөв хоорондын шилжүүлэг	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,494,421.8	9,017,318.6	10,035,057.2	9,317,220.8	12,106,504.7	11,661,700.9	15,137,298.8	13,904,273.0	16,204,102.7	15,630,443.9	17,913,488.5	20,475,301.0		

	2017		2018		2019		2020		2021		2022		2023	
	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Гүйцэтгэл	Батлагдсан	Төсөөлөл
А. УРСГАЛ ЗАРЛАГА	7,235,657.4	7,043,161.7	7,688,020.1	7,350,338.9	8,532,237.8	8,228,578.8	11,568,886.6	10,828,926.2	13,460,760.4	12,803,974.9	13,881,794.6	15,259,940.7		
1. Бараа, үйлчилгээний зардал	3,269,497.8	3,141,432.3	3,468,477.0	3,327,510.9	4,170,181.0	4,000,463.5	5,257,938.1	4,851,187.0	4,955,850.9	4,702,044.1	3,688,494.0	4,158,064.3		
1.1. Цалин, хөлс	1,815,359.5	1,800,434.6	1,900,270.6	1,878,939.8	2,282,377.7	2,256,967.2	2,716,519.9	2,648,895.0	2,593,011.4	2,531,733.2	1,599,621.0	1,891,677.9		
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,454,138.3	1,340,997.7	1,568,206.4	1,448,571.1	1,887,803.2	1,743,496.3	2,541,418.3	2,202,292.1	2,362,839.5	2,170,310.9	2,088,873.1	2,266,386.4		
2. ХҮҮ	1,156,688.1	1,156,465.1	1,150,740.0	1,046,419.8	865,585.5	860,980.8	978,957.1	939,200.6	971,544.6	835,652.2	909,075.3	1,180,634.6		
3. Татаас ба урсгал шилжүүлэг	2,809,471.5	2,745,264.2	3,068,803.1	2,976,408.1	3,496,471.4	3,367,134.5	5,331,991.4	5,038,538.5	7,533,364.9	7,266,278.7	9,284,225.3	9,921,241.8		
3.1. Татаас	289,103.4	260,619.2	245,311.8	230,028.7	320,105.9	298,900.8	458,233.1	375,070.7	500,978.5	453,698.2	489,600.5	608,346.2		
3.2. Урсгал шилжүүлэг	2,520,368.1	2,484,645.0	2,823,491.3	2,746,379.4	3,176,365.5	3,068,233.7	4,873,758.3	4,663,467.8	7,032,386.4	6,812,580.5	8,794,624.8	9,312,895.6		
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,904,940.2	1,658,140.7	2,058,472.3	1,680,430.2	3,405,545.0	3,016,672.2	3,514,071.5	3,034,235.9	3,304,662.2	2,982,240.7	4,296,294.0	5,347,310.6		
1. Барилга байгууламж	1,260,902.6	1,121,662.4	1,232,146.7	1,094,604.5	2,517,578.5	2,256,789.2	2,367,992.2	2,071,989.3	2,078,234.5	1,941,065.6	2,504,614.8	3,693,853.9		
2. Их засвар	76,563.2	66,992.7	92,169.5	89,888.4	179,758.9	161,645.2	172,235.8	144,987.8	147,215.2	128,506.7	99,740.6	169,533.1		
3. Тоног төхөөрөмж	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	261,668.8	527,354.6		
4. Хөрөнгийн бусад зардал	567,474.5	469,485.7	734,156.1	495,937.3	708,207.5	598,237.8	973,843.5	817,258.8	1,079,212.6	912,668.4	1,422,190.1	947,689.2		
5. Стратегийн нөөц хөрөнгө	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	8,079.7	8,879.7		
6. Төсвөөс эргэн төлөгдөх хөрөнгө оруулалт	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0		
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	353,824.2	316,016.2	288,564.8	286,451.7	168,722.0	416,449.8	54,340.7	41,110.9	-561,320.0	-155,771.7	-264,600.1	-131,950.3		
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	180,295.2	200,817.3	176,916.7	179,613.3	47,722.0	278,639.7	-170,168.6	-119,522.0	-712,320.0	-311,651.5	-544,600.1	-441,950.3		
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	173,529.0	115,198.9	111,648.1	106,838.4	121,000.0	137,810.1	224,509.3	160,632.9	151,000.0	155,879.8	280,000.0	310,000.0		
НИЙТ ТЭНЦЭЛ	-2,234,880.7	-1,059,054.0	-1,998,857.4	855,539.6	-834,022.9	378,626.5	-4,254,341.3	-3,460,106.4	-2,295,999.3	-1,324,087.3	-1,635,365.9	-880,683.0		
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-2,810,643.6	1,742,456.9	-2,630,348.9	27,859.3	-2,224,542.9	-756,190.0	-5,252,697.5	-4,440,434.8	-3,971,229.3	-2,919,009.2	-2,387,079.5	-1,553,401.6		



Доктор Ч.Нарантуяа нь МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгчээр ажилладаг. Тэрээр улс төрийн эдийн засгийн ухаанаар ОХУ-ын Москвагийн их сургуульд бакалавр, мөн Австрали Улсын Сиднейн их сургуульд эдийн засгийн ухааны магистрын зэрэг тус тус эзэмшсэн. 2012 онд АНУ-ын Мэрилэндийн их сургуульд бодлого судлалын докторын зэрэг хамгаалсан. 1993 оноос МУИС-д багшилж буй. 2009-2012 онд Эдийн засгийн сургуулийн Эдийн засгийн онолын тэнхимийн эрхлэгч, 2013-2017 онд МУИС-ийн Эдийн засаг, хөгжлийн бодлогын асуудал эрхэлсэн дэд захирлын албыг хашсан. Хөгжлийн эдийн засаг, Нийтийн секторын эдийн засаг, Институцийн эдийн засаг зэрэг хичээл заадаг. Засаглал, хэлцлийн зардал, институцийн чиглэлийн судалгааны асуудлыг сонирхдог. Сүүлийн жилүүдэд уул уурхайн салбар дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын орчин, уул уурхайн бус экспортыг дэмжих бодлого, жижиг дунд үйлдвэрийн хэлцлийн зардал зэрэг сэдвээр судалгаа хийсэн.